



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 11 сарын 02 өдөр

Дугаар 533

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох
тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 16 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Азийн хөгжлийн банкны “Зуд болон ой, хээрийн түймэртэй тэмцэх олон нийтийн чадавхийг бэхжүүлэх” төсөл болон бусад санхүүжилтээр барьж ашиглалтад оруулсан нийт 559,987,190.00 (таван зуун тавин есөн сая есөн зуун наян долоон мянга нэг зуун ерэн) төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг хавсралтад заасны дагуу Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Дорнод аймгийн Онцгой байдлын газарт эзэмшүүлж, үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Дорнод аймгийн Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Нармандах нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.2. Арга хэмжээний биелэлтийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132006334
28-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 11 дугаар сарын 02 өдрийн
533 дугаар тогтоолын хавсралт

ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗАР (ГАЛ ТҮЙМЭР УНТРААХ 53
ДУГААР АНГИ)-ЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр, байршил	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хөрөнгийн үнэ (төгрөг)
1	Дорнод аймаг Баян-Уул сум 4-р баг Бэрх, Онон 3 гудамж, Гал түймэр унтраах 53-р ангийн байр	2021	м2	308	366,817,507.00
2	Граж	2021	м2	150	164,599,683.00
3	Агуулах	2021	м2	64	6,870,000.00
4	Шалган нэвтрүүлэх байр	2021	м2	6	2,450,000.00
5	Амралтын байр	2021	м2	80	8,750,000.00
6	Жагсаалын талбай	2021	м2	570	3,500,000.00
7	Хашаа	2021	м2	1400	4,500,000.00
8	Сүүдрэвч	2021	м2	12	2,500,000.00
Нийт дүн					559,987,190.00 (таван зуун тавин есөн сая есөн зуун наян долоон мянга нэг зуун ер)